

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	20
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ
Н.ЭРДЭНЭБАЯР ТАНАА

2020.02.27 № 06/615
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн ерөнхий захирал Н.Эрдэнэбаяр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох, санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг хангах, элэгдэл нь дууссан үндсэн хөрөнгийн үнэ, ашиглагдах жилийг шинэчлэх, шатахуун зарцуулалтын норм, нормативыг мөрдөж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 25-наас 2020 оны 2 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Уваа уул аудит” ХХК-ийн захирал Ч.Мөнхтуяа, чанарын хяналтын менежер А.Оюун, аудитор Б.Буяндэлгэр, туслах аудитор Э.Номинчулуун хариуцаж хэрэгжүүлэв.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 40 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь “Чадварлаг баг, дэвшилтэд технологи инновацад тулгуурлан үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн тусламж үйлчилгээг үзүүлэхэд” оршино гэж тодорхойлжээ.

2019 онд “Донор, цус цусан бүтээгдэхүүний шинжилгээ, үйлдвэрлэл, цус сэлбэлт судлалын төрөлжсөн мэргэжлийн тусламж үзүүлэх” гэсэн зорилтын хүрээнд:

- Эмчилгээний заавар, стандарт, арга зүйн зөвлөмж боловсруулах;
- Цус сэлбэлтийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах;
- Судалгаа шинжилгээний ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах;
- Үйлчлүүлэгчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн цус цусан бүтээгдэхүүнийг тэгш хүртээмжтэй хүргэж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 2018 оны 80 дугаар тогтоолоор “Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай
- Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр тушаал, “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол “Журам шинэчлэн батлах тухай”.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус төвийн одоо мөрдөж байгаа 2018 онд батлагдан гарсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна

Цус сэлбэлт судлалын үндэсний төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Интерактив Би Ай” ХХК-ийн “Эмералд” программ хангамж ашигладаг байна.

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны 4 дүгээр улирлын Санхүүгийн үр дүнгийн тайланг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 7,748,349.6 мянган төгрөгөөс тооцон 77,483.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны 4 дүгээр улирлын Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 76,488.6 мянган төгрөгөөр тооцсон нь эрсдэлийн түвшинг “дунд” гэж үзсэнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 285,881.8 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материалын үлдэгдэл нэмэгдэж, өр төлбөр буурснаас шалтгаалсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	835.09	-	(835.09)
Авлага	54,854.39	52,773.30	(2,081.09)
Урьдчилгаа	179,239.31	12,415.78	(166,823.53)
Бараа материал	2,982,262.71	3,709,812.37	727,549.66
Үндсэн хөрөнгө	11,726,307.03	11,454,378.95	(271,928.08)
Нийт хөрөнгө	14,943,498.53	15,229,380.40	285,881.86
Өр төлбөр	31,003.29	1,988.95	(29,014.34)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	14,912,495.24	15,227,391.45	314,896.21
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	14,943,498.53	15,229,380.40	285,881.87

Авлага дансны үлдэгдэл нь 2019 онд Эрүүл мэндийн 20 байгууллагад цус, цусан бүтээгдэхүүн борлуулж авлага үүссэн ба хоорондын тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл буурсан нь 2018 оны 11 дүгээр сард 8 дугаар фактер нийлүүлэх гэрээ байгуулан бүтээгдэхүүнийг 2019 оны 3 дугаар сард хүлээн авсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн 8 дугаар фактерийн үлдэгдэл байгаагаас шалтгаалсан.

“8 дугаар фактер” гэдэг нь цус бүлэгнэлтийг дэмжихэд хэрэглэдэг Эрүүл мэндийн яамны өнчин эмийн жагсаалтад багтсан урьдчилан сэргийлэх тун юм. Энэ нь төр хариуцах эм, эмнэлгийн хэрэгсэл хөтөлбөрөөс зарцуулагддаг. Үлдэгдэл их байгаа нь Дэлхийн “Геомофил”-ийн холбооноос хандиваар ирсэн 2500 ширхэг 8 дугаар фактерийг эхэлж зарцуулсантай холбоотой юм.

Үндсэн хөрөнгө дансанд хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 1,237,192.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил нэмэгдсэн байна. Акталсан 366,162.5 мянган төгрөгийн хөрөнгө байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант үеийн элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт зориулан 6,543,050.1 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3,961,134.1 мянган төгрөгийг урсгал зардалд, 2,581,916.0 мянган төгрөгийг төр хариуцах эмнэлгийн тусламжийн зардалд зарцуулахаар батлагдсан.

Батлагдсан төсвөөс 5,022,604.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 1,520,445.4 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлыг зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 6,534,699.8 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 6,6659.8 мянган төгрөг зарцуулагдаагүй үлдсэнээс шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Гадаад төсөл хөтөлбөрөөс 8,550.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 85,037.9 мянган төгрөг, нийт 93,587.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалингийн зардалд 1,673.0 мянга, нийгмийн даатгалын зардалд 244.2 мянга, нормативд зардалд 5,808.0 мянга, эд хогшил худалдан авах зардалд 20,829.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 38,638.4 мянга, бусад урсгал шилжүүлгийн зардалд 21,965.2 мянга, нийт 89,157.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 4,430.1 мянган төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл нэмж тодорхойлж нийт 15 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 814,422.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 87,361.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 15,469.4 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 711,592.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгч байна. Үүнд:

1. Нийгмийн даатгалд 6,937.0 мянга, татварт 5,735.4 мянган төгрөгийг тухай бүр шалгаж тооцоо нийлээгүйгээс жилийн эцэст нийт 12,672.4 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” 20.2.6. “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй, “үнэн зөв байх”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх тооцоо нийлээгүй холбогдох ажилтанд хариуцлага тооцох, албан шаардлага өгөв.

2. Төлбөртэй үйлчилгээний орлого 2,797.0 мянган төгрөгийг нярав 5-10 хоногийн дараа дансанд тушаасан нь Сангийн сайдын 2012 оны 12дугаар сарын 21-ний өдрийн 276 дугаар тушаалын 2.6 “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэсэн заалттай нийцэхгүй, “эрх ба үүрэг”, “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөв.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Хандив тусламжаар ирсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтад анхаарал хандуулах шаардлагатай.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Цус сэлбэлтийн үндэсний төв байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 145 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 58,575.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож 633.9 мянган төгрөгийг барагдуулсан, 39,924.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хэрэгжүүлсэн байна.

Нийт 2 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмж хэрэгжсэн буюу зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Албан томилолтын зардалд 1,122.0 мянган төгрөг зарцуулсан боловч ажлын тайлангийн үр дүн тооцоогүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалттай нийцэхгүй, “Үнэн зөв байх”, “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэж тайлагнах, томилолтын тооцоо илүү, дутуу хийгдэх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах талаар зөвлөмж өгөв.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 72 тоот албан бичгээр Алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

2. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 710,153.0 мянган төгрөгийн хөрөнгө байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” гэсэн заалттай нийцэхгүй, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл:
Санхүүгийн тайлан үнэн бодитой илэрхийлэгдэхгүй байх, хөрөнгийн ашиглалт алдагдах.

2.3. Өгсөн зөвлөмж:
Дээрх зөрчлийг гаргахгүй байх, элэгдэл дууссан үндсэн хөрөнгийн үнэ, ашиглагдах жилийг шинэчлэн тогтоох.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 72 тоот албан бичгээр Алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

3. Зардлын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Автомашинд зарцуулсан шатахуунд норм лимитээр тооцож үзэхэд 253.8 мянган төгрөгийн шатахуун илүү олгосон.

Энэ нь Монгол Улсын Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаал "Жишиг норм батлах тухай" 1 дүгээр хавсралт, "Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм, тогтоосон" заалттай нийцэхгүй, "Үнэн зөв ба үнэлгээ" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Эрсдэл:

Батлагдсан төсөв хэтрэх, шатахууны тооцоо бодолт хангалтгүй байх.

3.3. Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, шатахууны тооцоог Монгол Улсын Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн 390 дугаар тушаалын дагуу бодож олгох.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 72 тоот албан бичгээр Алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

4. Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлттэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Албан хэрэгцээний hyundai tucson2.0 маркийн автомашинд 63.4 мянган төгрөгийн шатахуун илүү олгосон.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолоор баталсан "Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" 2. "Албан тушаалын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор хуанлийн хоног (баярын болон долоо хоногийн амралтын өдрийг оролцуулан)-т дунджаар 70 км, албан ажлын хэрэгцээний автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан суудлын автомашиныг хотын дотор ажлын хоногт дунджаар 50 км, дуудлагын автомашины хөдөлгүүрийн цилиндрийн багтаамж 2500 см³-ээс илүүгүй байхаар тогтоож, ажлын хоногт дунджаар 40 км-ээс тус тус хэтрүүлэхгүй хэрэглэж байхаар тогтоосугай" гэсэн заалттай нийцэхгүй, "Үнэн зөв ба үнэлгээ" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Эрсдэл:

Батлагдсан төсөв хэтрэх, төсвийг үр ашиггүй зарцуулах

4.3. Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, шатахууны тооцоог холбогдох журам зааврын дагуу бодож олгох.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2020 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 72 тоот албан бичгээр Алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,217,191,499.23	3,775,001,443.34
	МӨНГӨН ХӨРӨНГӨ	835,090.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	835,090.00	0.00
33	АВЛАГА	54,854,390.13	52,773,296.30
3351	Байгууллагаас авах авлага	54,853,546.13	52,773,295.30
3352	Хувь хүмүүсээс авах авлага	844.00	1.00
34	УРЬДЧИЛГАА	179,239,309.00	12,415,781.00
34600	Урьдчилж гарсан зардал	179,239,309.00	12,415,781.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,982,262,710.10	3,709,812,366.04
351	Түүхий эд материал	2,435,375,698.69	3,246,372,959.70
35110	Тусгай зориулалттай материал	470,520,590.61	396,343,230.76
35130	Эм боох материал	1,964,855,108.08	2,850,029,728.94
	Бэлэн бүтээгдэхүүн	431,211,236.56	367,452,778.82
354	Хангамжийн материал	115,675,774.85	95,986,627.52
35410	Бичиг хэргийн материал	14,824,059.66	10,365,057.11
35420	Аж ахуйн материал	22,264,143.64	30,321,795.62
	Сэлбэг хэрэгсэл	175,000.00	0.00
35440	Түлш, шатах тослох материал	1,659,329.81	1,334,004.02
35450	Барилгын засварын материал	3,239,700.00	4,448,669.05
35460	Хүнсний материал	59,113,041.74	35,116,601.72
3550	Бусад хангамжийн материал	14,400,500.00	14,400,500.00
	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	11,726,307,034.50	11,454,378,954.66
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,726,307,034.50	11,454,378,954.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,998,749,529.00	3,998,749,529.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-113,180,775.21	-183,683,715.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	94,507,000.00	77,507,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-85,454,686.50	-77,507,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	9,742,670,430.50	10,570,416,460.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-2,980,234,810.51	-3,937,373,051.43
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,091,710,437.49	1,151,994,737.49
39208	Хуримтлагдсан элэгдэл	-186,832,910.43	-308,752,811.37
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,043,300.00	5,043,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,043,300.00	-5,043,300.00
39301	Программ хангамж	80,392,055.00	80,392,055.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,380,474.84	-4,725,488.89
39303	Бусад биет бус хөрөнгө	87,361,240.00	87,361,240.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	14,943,498,533.73	15,229,380,398.00
	НИЙТ ӨР ТӨЛБӨР	31,003,290.00	1,988,948.00
	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	31,003,290.00	1,988,948.00
413	Өглөг	31,003,290.00	1,988,948.00
	Байгууллагад төлөх өглөг	31,003,290.00	1,988,948.00
	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	14,912,495,243.73	15,227,391,450.00
	Засгийн газрын хувь оролцоо	14,912,495,243.73	15,227,391,450.00
51	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,838,458,653.00	2,838,458,653.00
	Хуримтлагдсан үр дүн	11,487,490,894.63	11,802,387,100.90
51210	Өмнөх үеийн үр дүн	10,570,300,619.63	11,486,632,058.32
51220	Тайлант үеийн үр дүн	917,190,275.00	315,755,042.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	586,545,696.10	586,545,696.10
	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	14,943,498,533.73	15,229,380,398.00

4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,665,539,857.48	7,964,621,049.73
120	Нийтлэг татварын бус орлого	1,606,336,919.42	2,848,428,449.73
23	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,348,439,697.51	1,846,152,588.69
12004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,606,336,919.42	1,337,098,006.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэх	1,337,098,006.00	1,401,363,468.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэх	204,710,344.30	193,627,920.69
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	64,528,569.12	155,562,900.00
120005	Түрээсийн орлого	0.00	2,010,400.00
132	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	2,742,102,778.09	1,095,863,761.04
122001	Хандив тусламж-Дотоод	14,332,260.00	5,679,794.04
122002	Хандив-Гадаад	2,727,770,518.09	1,090,183,967.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,317,100,159.97	4,317,100,159.97
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,243,917,600.00	5,022,604,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	73,182,559.97	93,587,900.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,403,500.00	8,550,000.00
131102	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,733,359.97	0.00
131104	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,045,700.00	85,037,900.00
	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,748,349,582.48	7,648,866,007.46
	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,615,768,793.64	7,562,861,875.20
	УРСГАЛ ЗАРДАЛ	7,748,349,582.48	7,648,866,007.46
	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	681,045,304.40	942,045,166.00
210101	Үндсэн цалин	664,558,712.40	916,863,618.00
210102	Нэмэгдэл цалин	6,347,028.00	17,207,911.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,841,248.00	4,975,000.00
210104	Урамшуулал	7,298,316.00	2,998,637.00
	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	85,172,080.00	121,952,950.20
210201	Тэтгэврийн даатгал	65,410,194.50	94,763,752.20
210202	Тэтгэмжийн даатгал	8,319,725.90	11,429,549.10
210203	Эрүүл мэндийн даатгал	6,259,973.30	8,599,766.00
210204	ҮОМШӨ-ий даатгал	4,289,311.60	5,938,183.80
210205	Ажилгүйдлийн даатгал	892,874.70	1,221,699.10
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	372,065,330.68	146,547,361.48
210301	Гэрэл цахилгаан	80,029,521.00	131,478,535.00
210302	Цэвэр, бохир ус	14,032,017.74	3,352,615.66
210303	Түлш, халаалт	19,466,013.00	11,716,210.82
2104	Хангамж, бараа материалын зардал	109,706,596.56	38,239,042.24
210401	Бичиг хэрэг	1,657,540.21	8,115,023.90
210402	Тээвэр шатахуун	2,141,273.41	7,709,777.47
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,802,676.04	2,698,042.71
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,610,900.00	10,709,923.16
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,371,000.00	46,000.00
210408	Бараа материал акталсны зардал	94,123,206.90	8,960,275.00
2105	Нормативт зардал	6,272,555,937.00	4,667,653,058.36
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,554,406,844.07	2,308,164,821.95
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл-1	3,688,548,042.93	2,260,469,756.03

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210503	Нормын болон дүрэмт хувцас, зөөлөн эдлэл	4,332,500.00	0.00
210502	Хоол, Хүнс	25,268,550.00	99,018,480.38
	Эд хогшил, урсгал засварын зардал	12,560,670.00	44,461,716.08
210601	Багаж, техник хэрэгсэл	0.00	15,743,978.38
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	3,333,500.00	0.00
210604	Урсгал засвар	9,227,170.00	28,717,737.70
	Томилолт, зочны зардал	217,870.00	1,394,000.00
210702	Дотоод албан томилолт	217,870.00	1,394,000.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,789,640.00	35,813,820.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	24,601,500.00	25,758,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,349,200.00	2,365,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	851,400.00	784,532.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	267,150.00	215,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,197,680.00	5,777,288.00
210807	Газрын төлбөр	712,800.00	658,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,732,910.00	200,000.00
	Бараа үйлчилгээний бусад зардал	305,193,143.94	1,564,754,760.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,655,365.00	46,655,365.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	258,537,778.94	1,509,120,979.84
	Бусад урсгал шилжүүлэг	17,954,400.00	14,920,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,954,400.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	14,920,000.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	114,626,388.84	71,084,132.26
213303	Төвлөрүүлэг шилжүүлэг	114,626,388.84	71,084,132.26
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	917,190,275.00	315,755,042.27

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (0)	5,896,036,988.62	6,694,106,701.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,578,936,828.65	1,577,914,101.15
120	Нийтлэг татварын бус орлого	1,578,936,828.65	1,577,914,101.15
12004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,578,936,828.65	1,577,914,101.15
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,375,312,432.65	1,396,446,826.15
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос	203,624,396.00	179,456,875.15
120005	Түрээсийн орлого	0.00	2,010,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,317,100,159.97	5,116,192,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,243,917,600.00	5,022,604,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,243,917,600.00	5,022,604,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	73,182,559.97	93,587,900.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	8,403,500.00	8,550,000.00
131102	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	50,733,359.97	0.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	14,045,700.00	85,037,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,895,412,778.62	6,694,941,791.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,895,412,778.62	6,694,941,791.15
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,762,831,989.78	6,600,942,406.89
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	666,478,037.00	949,650,433.00
210101	Үндсэн цалин	409,667,837.00	583,606,933.00
210102	Нэмэгдэл	97,602,500.00	232,774,800.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	59,611,900.00	75,075,000.00
210104	Урамшуулал	99,595,800.00	58,193,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,572,800.00	128,221,506.00
210201	Тэтгэврийн даатгал	76,640,300.00	80,822,506.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,586,500.00	9,479,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,855,700.00	17,063,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,317,300.00	1,896,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,173,000.00	18,959,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,527,551.74	146,547,361.48
210301	Гэрэл, цахилгаан	80,029,557.00	131,478,535.00
210302	Түлш, халаалт	19,466,013.00	11,716,210.82
210303	Цэвэр, бохир ус	14,031,981.74	3,352,615.66
2104	Хангамж, бараа материалын зардал	35,717,256.04	35,213,838.61
210401	Бичиг хэрэг	8,407,380.00	5,013,022.90
210402	Тээвэр, шатахуун	7,128,000.00	7,128,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,823,676.04	1,968,555.71
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	18,358,200.00	21,058,260.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	46,000.00
2105	Нормативт зардал	4,695,458,635.00	5,150,672,634.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,575,134,245.00	5,032,856,500.00

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210503	Хоол, хүнс	116,625,790.00	113,756,634.00
210502	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,698,600.00	4,059,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,694,470.00	55,354,987.70
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,705,000.00	20,162,580.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,131,000.00	648,000.00
210604	Урсгал засвар	12,858,470.00	34,544,407.70
2107	Томилолт, зочны зардал	1,191,870.00	1,394,000.00
210702	Дотоод албан томилолт	1,191,870.00	1,394,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,055,230.00	49,932,365.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	29,155,500.00	29,158,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,240,000.00	2,365,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	851,400.00	784,532.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	267,150.00	215,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	77,000.00	55,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,890,680.00	5,925,333.10
210807	Газрын төлбөр	712,800.00	658,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,860,700.00	10,770,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	73,136,140.00	83,955,281.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	73,136,140.00	83,955,281.00
2132	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	132,580,788.84	93,999,384.26
	Засгийн газрын урсгал шилжүүлэг	114,626,388.84	71,084,132.26
	Засгийн газрын дотоод шилжүүлэг	114,626,388.84	71,084,132.26
	Бусад урсгал шилжүүлэг	17,954,400.00	17,954,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	17,954,400.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	22,915,252.00
	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	624,210.00	-835,090.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	210,880.00	835,090.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	835,090.00	0.00

4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,751,097,413.00	215,438,378.00	10,570,566,669.63	13,537,102,460.63
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-266,050.00	-266,050.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,751,097,413.00	215,438,378.00	10,570,300,619.63	13,536,836,410.63
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	371,107,318.10	00.00	371,107,318.10
D05	Үндсэн хөрөнгийн бууралт	87,361,240.00	00.00	00.00	87,361,240.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	917,190,275.00	917,190,275.00
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,838,458,653.00	586,545,696.10	11,487,490,894.66	14,912,495,243.76
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-858,836.03	-858,836.03
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,838,458,653.00	586,545,696.10	11,486,632,058.63	14,911,636,407.73
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	315,755,042.27	315,755,042.27
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,838,458,653.00	586,545,696.10	11,802,387,100.90	15,227,391,450.00

4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		835,090.00		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,543,050,100.00	6,534,699,758.19	8,350,341.81	99.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,543,050,100.00	6,534,699,758.19	8,350,341.81	99.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,541,750,100.00	6,533,749,758.19	8,000,341.81	99.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	947,980,500.00	947,977,488.00	3,012.00	100.00
210101	Үндсэн цалин	581,937,000.00	581,933,988.00	3,012.00	100.00
210102	Нэмэгдэл	232,774,800.00	232,774,800.00	-	100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	75,075,000.00	75,075,000.00	-	100.00
210104	Урамшуулал	58,193,700.00	58,193,700.00	-	100.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	127,977,300.00	127,977,300.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	80,578,300.00	80,578,300.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,479,800.00	9,479,800.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,063,600.00	17,063,600.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,896,000.00	1,896,000.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	18,959,600.00	18,959,600.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	153,207,200.00	146,547,361.48	6,659,838.52	95.65
210301	Гэрэл, цахилгаан	135,763,000.00	131,478,535.00	4,284,465.00	96.84
210302	Түлш, халаалт	13,180,700.00	11,716,210.82	1,464,489.18	88.89
210303	Цэвэр, бохир ус	4,263,500.00	3,352,615.66	910,884.34	78.64
2104	Хангамж, бараа материалын зардал	35,268,600.00	35,213,838.61	54,761.39	99.84
210401	Бичиг хэрэг	4,086,200.00	5,013,022.90	(926,822.90)	122.68
210402	Тээвэр, шатахуун	7,128,000.00	7,128,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,890,300.00	1,968,555.71	(78,255.71)	104.14
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	21,802,900.00	21,058,260.00	744,640.00	96.58
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	361,200.00	46,000.00	315,200.00	12.74
2105	Нормативт зардал	5,145,168,900.00	5,144,864,634.00	304,266.00	99.99
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,027,344,500.00	5,027,048,500.00	296,000.00	99.99
210502	Хоол, хүнс	114,050,000.00	113,756,634.00	293,366.00	99.74
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,774,400.00	4,059,500.00	(285,100.00)	107.55
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,632,500.00	34,525,890.00	106,610.00	99.69
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,712,500.00	10,223,580.00	488,920.00	95.44
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,336,500.00	648,000.00	688,500.00	48.48
210604	Урсгал засвар	22,583,500.00	23,654,310.00	(1,070,810.00)	104.74
2107	Томилолт, зочны зардал	1,420,000.00	1,394,000.00	26,000.00	98.17
210702	Дотоод албан томилолт	1,420,000.00	1,394,000.00	26,000.00	98.17
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	50,615,100.00	49,932,365.10	682,734.90	98.65
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн	29,163,700.00	29,158,000.00	5,700.00	99.98

Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж				
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,475,000.00	2,365,000.00	110,000.00	95.56
210803	Даатгалын үйлчилгээ	851,400.00	784,532.00	66,868.00	92.15
210804	Тээврийн хэрэгслийн татвар	396,000.00	215,200.00	180,800.00	54.34
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	89,100.00	55,000.00	34,100.00	61.73
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,037,100.00	5,925,333.10	111,766.90	98.15
210807	Газрын төлбөр	712,800.00	658,800.00	54,000.00	92.42
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	10,890,000.00	10,770,500.00	119,500.00	98.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	45,480,000.00	45,316,881.00	163,119.00	99.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,480,000.00	45,316,881.00	163,119.00	99.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,300,000.00	950,000.00	350,000.00	73.08
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,300,000.00	950,000.00	350,000.00	73.08
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,300,000.00	950,000.00	350,000.00	73.08
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,022,604,700.00	5,022,604,700.00	-	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,022,604,700.00	5,022,604,700.00	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	5,022,604,700.00	5,022,604,700.00	-	100.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,520,445,400.00	1,577,914,101.15	(57,468,701.15)	103.78
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,390,445,400.00	1,428,681,817.30	(38,236,417.30)	102.75
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	130,000,000.00	149,232,283.85	(19,232,283.85)	114.79
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		835,090.00	(835,090.00)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-	-	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	69	69	(2)	102.90
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	57	57	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	11	11	-	100.00
620004	Гэрээт ажилтан		2	(2)	

4.6. Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		89,157,900.70
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		89,157,900.70
Бараа, үйлчилгээний зардал		67,192,648.70
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,672,945.00
Үндсэн цалин		1,672,945.00
Нийгмийн даатгалын шимтгэл		244,206.00
Хангамж, бараа материалын зардал		0.00
Бичиг хэрэг		0.00
Нормативт зардал		5,808,000.00
Эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл		5,808,000.00
Эд хогшил худалдан авах		20,829,097.70
Багаж, техник, хэрэгсэл		9,939,000.00
Урсгал засвар		10,890,097.70
Бараа үйлчилгээний бусад зардал		38,638,400.00
Бараа үйлчилгээний бусад зардал		38,638,400.00
Бусад урсгал шилжүүлэг		21,965,252.00
Бусад урсгал шилжүүлэг		21,965,252.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		93,587,900.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		93,587,900.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		8,550,000.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		0.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		85,037,900.00

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2019			САГ-2020/135/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Цус сэлбэлт судлалын үндэсний төв		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Нийгмийн даатгал, татварын тайлангаа тухай бүр шалгаж тооцоо нийлээгүйгээс жилийн илүү шилжүүлсэн.	12,672.4	Албан шаардлага өгөх	Ахлах нягтлан бодогч	Ө.Бат-Эрдэнэ
2	Төлбөртэй үйлчилгээний орлогыг нярав 5-10 хоногийн дараа дансанд тушаасан.	2,797.0	Албан шаардлага өгөх	Ахлах нягтлан бодогч Нярав	Ө.Бат-Эрдэнэ Б.Алтанзул
3	Албан томилолтын ажлын тайлан бичээгүй.	1,122.0	Зөвлөмж өгөх	Ахлах нягтлан бодогч	Ө.Бат-Эрдэнэ
4	Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө байна.	710,153.0	Зөвлөмж өгөх	Ахлах нягтлан бодогч	Ө.Бат-Эрдэнэ
5	Автомашинд зарцуулсан шатахуунд норм лимитээр тооцож үзэхэд шатахуун илүү олгосон.	253.8	Зөвлөмж өгөх	Ахлах нягтлан бодогч	Ө.Бат-Эрдэнэ
6	Албан хэрэгцээний hyundai tucson2.0 маркийн автомашинд шатахуун илүү олгосон.	63.4	Зөвлөмж өгөх	Ахлах нягтлан бодогч	Ө.Бат-Эрдэнэ
	НИЙТ ДҮН	727,061.6			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 02 дугаар сарын 28

№ 02/36

Улаанбаатар хот

С/АГ- 0020/135/СТА- ПШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан цаглабарт хугацаанд Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нийгмийн даатгал, татварт тооцоо нийлж ажиллаагүйгээс жилийн эцэст илүү мөнгө шилжүүлж 12,672.5 төгрөгийн авлага үүсгэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" 20.2.6. "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх..." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж биелэлтийг Төрийн аудитын газарт 2020 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлэхийг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн захирал Н.Эрдэнэбаяр, ахлах нягтлан бодогч Ө.Бат-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР

Э.ЭНХБААТАР
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Ч.МӨНХТУЯА

ЗӨВШӨӨРСӨН:

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ

Н.ЭРДЭНЭБАЯР

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН АХЛАХ
НЯГТЛАН БОДОГЧ

Ө.БАТ-ЭРДЭНЭ

Акт, албан шаардлагыг биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг уурэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie_Kheree\Alban_Shaardlaga\2020\0228SAG7.Docx

001080124



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 02 дугаар сарын 28

№ 02/37

Улаанбаатар хот

САН-10020/135/СТА-ТМЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасан цаглабарт хугацаанд Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлбөртэй үйлчилгээний орлогоос 2,797.0 мянган төгрөгийг 5-10 хоногийн дараа төсөвт тушаасан нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 2.6 “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг /түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх...” Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1-д гэсэн заалтуудыг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 25-ны дотор Санхүүгийн аудитын газарт ирүүлэхийг Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн захирал Н.Эрдэнэбаяр, ахлах нягтлан бодогч Ө.Бат-Эрдэнэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР
Ө.ЭНХБААТАР
УВАА УУЛ АУДИТ ХХК-ийн
ЗАХИРАЛ

900610
Ч МӨНХТУЯА

ЗӨВШӨӨРСӨН:
ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ
Н.ЭРДЭНЭБАЯР

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН АХЛАХ
НЯГТЛАН БОДОГЧ
Ө.БАТ-ЭРДЭНЭ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд харууцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.